



БАНКНЫ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

МБГ, БХЗХ-ийн эдийн засагч Х.Саруул

2016 оны 1 дүгээр сар

ХУРААНГУЙ

Банкны зээлийн судалгаа нь аж ахуй нэгж болон өрхүүдэд зээл олгоход тавигдах шалгуур, нөхцөл, мөн зээлийн эрэлтийг банкууд хэрхэн үнэлж байгааг илрүүлэх зорилготой чанарын судалгаа юм. Илүү оновчтой хэлбэл, банкны зээлийн судалгаа нь зээл олголтын өөрчлөлтийг нийлүүлэлтийн болон эрэлтийн хүчин зүйлээр ялган харах гол зорилгыг агуулна. Энэхүү судалгааны ажлаар банкны зээлийн судалгааг авч тайлагнах шаардлага, бусад улс орнуудын туршлага, одоо авч буй судалгааг сайжруулах арга замыг судлахыг зорилоо.

Түлхүүр үгс: банкны зээлийн судалгаа, зээлийн нөхцөл, зээлийн шалгуур, мөнгөний бодлогын шилжих механизм

JEL ангилал: E5, E51

I. УДИРТГАЛ


Эдийн засаг дахь зээлийн орчин, түүний төлөв хандлагыг тодорхойлох зорилгоор гадаадын улс орнуудад улирал тутам явуулдаг Банкны зээлийн судалгаа (БЗС)-г 2012 оноос Монголбанк Зээлийн төлөвийн судалгаа нэртэйгээр явуулсан. Монголбанкнаас явуулж буй Зээлийн төлөвийн судалгаа нь бусад орнуудын ижил төрлийн судалгаатай харьцуулахад бүтэц, агуулга, давтамжийн хувьд ялгаатай бөгөөд энэ нь уг судалгааны ач холбогдлыг бууруулж байна. Энэхүү танилцуулгаар БЗС-ны ач холбогдлыг тодорхойлж, одоо явуулж буй судалгааны сул тал, тэдгээрийг цаашид сайжруулах боломжийг судлахыг зорилоо.

БЗС нь аж ахуй нэгж болон өрхүүдэд зээл олгоход тавигдах шалгуур, нөхцөл, мөн зээлийн эрэлтийг банкууд хэрхэн үнэлж байгааг илрүүлэх зорилготой чанарын судалгаа юм. Илүү оновчтой хэлбэл, БЗС нь зээл олголтын өөрчлөлтийг нийлүүлэлтийн болон эрэлтийн хүчин зүйлээр нь ялгаж харуулах гол зорилгыг агуулна. Энэ төрлийн судалгааг Евро бүс, Америк, Япон зэрэг дэлхийн хөгжингүй орнуудад улирал тутам явуулдаг бөгөөд эдгээр орнуудын судалгаа нь дэлхийн бусад орнуудад жишиг болсон байдаг. Тухайлбал, 2009 оноос дээрх орнуудын судалгааны аргачлалыг ашиглан Олон Улсын Санхүүгийн Институт дэлхийн эрчимтэй хөгжиж буй 126 орноос банкны зээлийн судалгааг авч эхэлсэн байна.

II. БАНКНЫ ЗЭЭЛИЙН СУДАЛГААГ ЯВУУЛАХ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ

БЗС-г авч, тайлагнах хоёр гол шалтгаан байна. Нэгдүгээрт, уг судалгаа нь банкны зээл олгох үйл хөдлөл, түүний мөнгөний бодлогын шилжих механизмд үзүүлэх нөлөөллийн талаар илүү бодитой мэдээлэл өгдөг (Зураг 1). Америкийн Холбооны нөөцийн банк хамгийн олон жил буюу 1967 оноос хойш БЗС-г явуулж байгаа тул уг судалгааны ач холбогдол, үр дүнг судалсан олон ажил хийжээ. Холбооны Нөөцийн банкны эдийн засагч Lown, Morgan, болон Rohtagi (2000) нар банкууд зээлийн шалгуур нөхцөлийг тодорхойлохдоо өөрийн зээл олгох боломж, ирээдүйн талаарх хүлээлт зэрэгт тулгуурладаг бөгөөд зээлийн шалгуур, нөхцөл нь бусад макро эдийн засгийн хувьсагчидтай харьцуулахад харьцангуй экзоген хувьсагч байдаг гэжээ. Тиймээс дээрх эдийн засагчид БЗС-г цаашид тогтмол явуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Зураг 1. Банкны зээл олголтыг тодорхойлогч хүчин зүйлс



Эх сурвалж: Евро бүсийн зээлийн судалгаа, 2005

Зээлийн төлөв, хандлагыг зөв тодорхойлох нь бодлого боловсруулагчдын шийдвэр гаргалтад нөлөөлнө. Тухайлбал, зээл олголтод эрэлтийн хүчин зүйлс илүү давамгайлж байна уу, нийлүүлэлтийн хүчин зүйлс илүү давамгайлж байна уу гэдгээс

шалтгаалан бодлогын сонголт өөрчлөгддөг. Энгийн жишээ хэлэхэд **Төв банк мөнгөний зөөлөн бодлого явуулахаар төлөвлөж байсан боловч БЗС-аар банкууд төсөөлж байснаас илүү ихээр зээл олгох сонирхолтой байгаа нь илэрхий болвол мөнгөний бодлогыг зөөлрүүлэх хэмжээг бууруулах боломжтой.**

Хоёрдугаарт, зээл олголт нь эдийн засгийн мөчлөгийг тодорхойлдог хөтөч үзүүлэлт байдаг тул эдийн засгийн хэлбэлзлийг таамаглахад ашиглагдах боломжтой. Европын Төв банк мөн Америкийн Холбооны Нөөцийн банк БЗС-аар зээл олголт болон эдийн засгийн өсөлтийг таамаглах боломжтой эсэхийг судалсан байна. Европын Төв банкнаас 2010 онд хийсэн судалгаагаар БЗС нь зээлийн өсөлт мөн ДНБ-ий өсөлтийг өндөр ач холбогдолтойгоор таамагладаг гэсэн үр дүн гарчээ³⁰. Америкийн Холбооны Нөөцийн банкны эдийн засагч Lown болон Morgan нарын 2006 онд хийсэн судалгаагаар БЗС-ны үр дүнд зээлийн шалгуур, нөхцөлөө чангаруулсан банкуудын эзлэх хувь огцом өсөх тохиолдолд удалгүй эдийн засгийн хямрал болж байгаа зүй тогтол ажиглагдсан байна (1982 оны хямралаас бусад бүх эдийн засгийн хямралуудад ажиглагдсан).

³⁰ The Euro Area Bank Lending Survey Matters: Empirical evidence for credit and output growth by Gabe de Bondt, Angela Maddaloni, Jose-Luis Peidro and Silvia Scovel, 2010, Working Paper Series, European Central Bank

III. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

Дэлхийн бусад орны банкны зээлийн судалгааны бүтэц ерөнхийдөө ижил төстэй. Зээлийн шалгуур, зээлийн нөхцөл, зээлийн эрэлт, мөн тухайн цаг үетэй холбоотой нэмэлт асуулт гэсэн бүлэг асуултуудаас бүрдэнэ. Холбооны Нөөцийн банк хамгийн анх БЗС судалгааг явуулж эхэлсэн тухай дээр дурдсан. Тэгвэл Японы Төв банк 2000 оноос Холбооны Нөөцийн банкны туршлагад тулгуурлан БЗС-г явуулж эхэлсэн байна. Америкийн холбооны нөөцийн банк, Японы төв банк, Евро бүс болон Олон улсын санхүүгийн институтаас явуулдаг БЗС-нуудыг Хүснэгт 1-т харьцуулан харуулав.

Хүснэгт 1. Бусад улсын БЗС-ны харьцуулалт

	Америкийн Холбооны Нөөцийн банк	Японы Төв банк	Европын Төв банк	Олон Улсын Санхүүгийн Институт
Судалгааны нэр	Банкны зээлийн ахлах мэргэжилт-нүүдийн зээлийн талаарх санал бодлын судалгаа	Японы том банкуудын зээлийн ахлах мэргэжилт-нүүдийн зээлийн талаарх санал бодлын судалгаа	Евро бүсийн банкны зээлийн судалгаа	Эрчимтэй хөгжиж буй орнуудын банкны зээлийн төлөвийн судалгаа
Авч эхэлсэн он	1967 он	2000 он	2003 он	2009 он
Давтамж	Улирал тутамд	Улирал тутамд	Улирал тутамд	Улирал тутамд
Түүврийн хэмжээ	Холбооны нөөцийн 12 дүүргийн 60 том дотоодын банк	Японы том хэмжээтэй 50 банк	Евро бүсийн нийт зээл олголтын 40 хувийг хамардаг 86 том банк.	Ази, Европ, Латин Америк, Африк тивийн эрчимтэй хөгжиж буй орнуудын 130 банк
Судалгаанд оролцогч	Зээлийн ахлах мэргэжилтэн	Зээлийн ахлах мэргэжилтэн	Зээлийн ахлах мэргэжилтэн	Зээлийн ахлах мэргэжилтэн
Хариултуудыг нэгтгэхэд ашигладаг индекс	Цэвэр хувь ³²	Тархалтын индекс ³³	Цэвэр хувь мөн Тархалтын индекс	Тархалтын индекс

³¹ Net percentage

³² Diffusion index

Сүүлд гаргасан тайлангийн хуудасны тоо	63 хуудас (2015 оны 2-р улирлын тайлан)	9 хуудас (2015 оны 4-р улирлын тайлан)	50 хуудас (2015 оны 4-р улирлын тайлан)	19 хуудас (2015 оны 1-р улирлын тайлан)
БЗС-ны тайлангийн бүтэц	1. Эхлэл, хураангуй 2. Хавсралтаар судалгааны тоон өгөгдлийг асуулт бүрээр хүснэгтэд оруулж харуулна	1. Асуулт тус бүрийн хариултыг тархалтын индекс ашиглан нэгтгэж, үр дүнг нэмэлт хүснэгт, графикаар харуулна	1. Эхлэл, хураангуй 2. Асуултуудыг ерөнхий бүлгээр нь ангилан цэвэр хувиар нэгтгэж, үр дүнг графикаар харуулна 3. Хавсралтаар судалгааны тоон өгөгдлийг асуулт бүрээр хүснэгтэд оруулж харуулна. 4. Нэр томъёоны тайлбар	1. Эхлэл, хураангуй 2. Бүс бүрээр зээлийн төлөвийг нэгтгэн харуулна. Хөгжингүй орнуудын БЗС-ны үр дүнтэй харьцуулна 3. Асуулт тус бүрийн хариултыг нэгдсэн индексээр харуулна 4. Нэмэлт тайлбар
Банкуудыг хэмжээгээр нь жигнэдэг эсэх	Том банкуудыг сонгодог учраас жигнэдэггүй. Харин индексийг нийт банкууд, том банкууд, бусад банкууд гэсэн 3 ангиллаар тооцно.	Том банкуудыг сонгодог учраас жигнэдэггүй.	Банк тус бүрийг жигнэдэггүй харин улс орны түвшинд зээлээр нь жигнэдэг.	Ямар банкуудыг сонгодог нь тодорхойгүй байна. Улс орны түвшинд жигнэдэггүй.

IV. МОНГОЛБАНКААС ЯВУУЛСАН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА, ТҮҮНИЙ СУЛ ТАЛ


4.1. Зээлийн төлөвийн судалгааг бодит байдалтай харьцуулсан үр дүн

Монголбанкнаас 2012, 2014, 2015 онуудад авсан Зээлийн төлөвийн судалгаанд зээл олголтыг онцлон асуусан асуултууд орсон байдаг. Гэтэл зээл олголт гэдэг нь зах зээл дэх тэнцвэрийн цэгүүдийг хэлэхээс биш эрэлтийн болон нийлүүлэлтийн хүчин зүйлсийг ялган харуулж чадахгүй. Тиймээс бусад оронд зээлийн шалгуур, нөхцөл хэрхэн

өөрчлөгдснийг асуух замаар зээлд нөлөөлсөн нийлүүлэлтийн хүчин зүйлийг илрүүлэхийг оролддог.

Хэдийгээр зээл олголтын талаарх асуулт нь энэ төрлийн судалгаанд байдаггүй ч Монголбанкнаас авсан Зээлийн төлөвийн судалгаанд банкууд хэр бодитой хариулсныг банкны тайлан тэнцэл дээрх үр дүнтэй харьцуулж³³, Зураг 2-т харуулав.

Зураг 2. Зээлийн төлөвийн судалгааны хариулт ба гүйцэтгэл



Зээл олголт хэрхэн өөрчлөгдсөн талаарх асуултуудад 2012 онд нийт 48 хариулт ирүүлснээс 24, 2014 онд 40 хариултаас 20, 2015 онд 36 хариултаас 10 хариулт нь тус тус бодит байдалтай огт нийцээгүй үр дүн гарсан байна. Зээл олголттой холбоотой асуултуудын гол агуулга нь “Танай банкны зээл олголт өнгөрсөн 3 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн бэ? Ирэх 3 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөнө гэж хүлээж байна вэ?” гэсэн асуултуудаас бүрдэнэ. Өнгөрсөн 3 сарын хугацаанд банкны зээл олголт нэмэгдсэн эсвэл буурсан эсэхийг угтаа судалгаанд хамрагдагсад хамгийн сайн мэдэж байх ёстой. Гэтэл бодит байдалтай огт нийцээгүй хариултын тоо өндөр байна. Үүнийг хэд хэдэн шалтгаанаар тайлбарлаж болох юм. Тухайлбал,

1. Түүврийн сул тал – Судалгаанд банкны зээл олголтын талаар мэдээлэл сайтай холбогдох ажилтныг хамруулаагүй байж болно.
2. Судалгааны асуулга хэт нурууу байснаас банкны төлөөлөл судалгаанд ач холбогдол өгч хариулаагүй байж болно.
3. Тодорхой бус байдал – Дээр дурдсанчлан ирээдүйд чиглэсэн

³³ Харьцуулалтыг хэрхэн гүйцэтгэснийг Хавсралт D-с харна уу.

асуултуудад хариулахад тодорхой бус байдал нөлөөлсөн байж болзошгүй. Гэхдээ энэ таамаглалыг судалгааны үр дүнгээс хялбархан няцааж болно. Учир нь банкууд ирээдүйд чиглэсэн асуултад өнгөрсний талаарх асуултуудаас хавьгүй оновчтой хариулсан байгаа юм.

4.2. Монголбанкнаас явуулсан Зээлийн төлөвийн судалгааны сул тал

Судалгааг явуулсан хугацаа, давтамж

Монголбанкнаас БЗС-г 2012 оны 11 дүгээр сард, 2014 оны 8 дугаар сард мөн 2015 оны 2 дугаар сард буюу нийт 3 удаа явуулсан байна.

Америк, Япон, Европ мөн дэлхийн эрчимтэй хөгжиж буй улс орнуудын туршлагаас харахад БЗС-г улирал бүрийн эхний сард тогтмол явуулж байна. Зээлийн төлөв ямар байх вэ гэдэг нь улирлын шинжтэй асуудал. Ялангуяа жилийн 4 улиралтай манай орны хувьд эдийн засаг идэвхждэг саруудад зээлийн эрэлт нэмэгдэж, үүнийг дагаад зээлийн төлөв өөрчлөгдөж байдаг. Монголбанкнаас БЗС-г жилд ганц удаа явуулдаг бөгөөд жил бүр ялгаатай саруудад явуулсан тул улирлын нөлөөллийг ялган харах, гурван жилийн үр дүнг харьцуулахад хүндрэлтэй юм.

Судалгааны түүвэр

Зээлийн төлөвийн судалгааг явуулахдаа эхний хоёр судалгаанд Монголбанкнаас төлөөлөгч томилж, банкны төлөөлөлтэй уулзан хариултыг авсан бол сүүлийн судалгаанд асуулгын хуудсыг банкуудад илгээж, хариултыг авсан байна. Банкуудад биеэр очиж судалгааг авах явцад судалгаанд хариулт өгч байсан ажилтан “зарим асуултад банкнийг төлөөлж хариулт өгөх боломжгүй”, “энэ талаар сайн мэдэхгүй” зэрэг хариултыг өгөх тохиолдлууд нэлээд гарч байсан тухай уг судалгааг хариуцсан ажилтнууд хэлж байсан.

Монголбанкнаас 2012 оны 11 дүгээр сард явуулсан БЗС-нд банк тус бүрээс дараах албан тушаалын ажилтнуудыг хамруулсан байна (Хүснэгт 2). Зээлийн төлөвийн судалгаанд зээлийн нөхцөл³⁴ болон шалгуур³⁵-ын талаар санал боловсруулдаг эсвэл шийдвэр гаргадаг ажилтнуудыг хамруулах нь зүйтэй. Иймд Хүснэгт 3-ын сүүлийн баганад банк тус

³⁴ *Зээлийн нөхцөл (Credit terms and conditions)* Зээлдүүлэгч болон зээлдэгчийн харилцан тохиролцсон зээлийн дүн, хугацаа, хүү болон бусад нөхцөлийг ойлгоно (Нэр томъёоны тайлбараас)

³⁵ *Зээлийн шалгуур (Credit standards)* Зээлдэгчийг зээлийн шаардлага хангах эсэхийг тодорхойлдог банкны дотоод журам, аргачлал, процедур. Тухайлбал, зээлдэгчийн өр-орлогын харьцааг тооцож, тодорхой хязгаар заах.

бүрийн зээлийн нөхцөлийн талаар санал боловсруулж, шийдвэр гаргадаг газар, хэлтсийг судалж жагсаав (Банкуудын мэдээллийг нууцлах зорилгоор банк болоод судалгаанд хамрагдсан ажилтны нэрийг дурдаагүй болно).

Хүснэгт 2. БЗС-нд хариулт өгсөн ажиллагсдын нэр, албан тушаал			
№	Судалгаанд хамрагдсан банк	Судалгаанд хариулсан ажилтны нэр, албан тушаал	Уг банкинд зээлийн нөхцөлийн талаарх санал боловсруулдаг болон шийдвэр гаргадаг газрууд
1.	Банк 1	Гүйцэтгэх захирлын ажлын албаны дарга	Зээлийн бодлого зохицуулалтын газар бүх зээлийн бүтээгдэхүүний хувьд санал боловсруулна → Актив, пассивын хороо шийдвэрлэнэ.
2.	Банк 2	Зээлийн хорооны гишүүд	Иргэдийн банкны газар, Байгууллагын банкны газар өөрийн хариуцсан зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр санал боловсруулна → Актив, пассивын хороо шийдвэрлэнэ.
3.	Банк 3	Багцын эрсдэлийн менежер	Санхүү удирдлагын газар санал боловсруулна → Актив, пассивын хороо шийдвэрлэнэ.
4.	Банк 4	Зээлийн бодлогын хэлтсийн захирал	Зээлийн бодлогын газар санал боловсруулна → Актив, пассивын хороо шийдвэрлэнэ.
5.	Банк 5	Зээл хариуцсан захирал	Иргэдийн банкны газар, Байгууллагын банкны газар хариуцсан зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр санал боловсруулна → Эрсдэлийн удирдлагын хороо шийдвэрлэнэ.
6.	Банк 6	Эрсдэлийн удирдлагын газрын захирал	Зээлийн бодлого, зохицуулалтын газар санал боловсруулна → Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.
7.	Банк 7	Байгууллагын банкны газрын захирал	Иргэдийн банкны газар, Байгууллагын банкны газар хариуцсан зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр санал боловсруулна → Актив, пассивын хороо шийдвэрлэнэ.
8.	Банк 8	Зээлийн ахлах эдийн засагч	Иргэдийн банкны газар, Байгууллагын банкны газар мөн Эрсдэлийн удирдлагын газар санал боловсруулна → Актив, пассивын хороо шийдвэрлэнэ.
9.	Банк 9	Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал	Иргэдийн банкны газар бүх зээлийн бүтээгдэхүүний санал боловсруулна → Гүйцэтгэх захирал батална.

10. Банк 10	Зээлийн удирдлагын газар	Хөрөнгө зохицуулалтын газар, Иргэдийн банкны газар, Байгууллагын банкны газар хамтран зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр санал боловсруулна → Актив, пассивын хороо шийдвэрлэнэ.
-------------	--------------------------	---

Эдгээр банкуудад ихэвчлэн Иргэдийн болон Байгууллагын банкны газрууд зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн нөхцөлийг тодорхойлж санал боловсруулан, Актив пассивын хороогоор шийдвэрлүүлдэг байна. Мөн эрсдэлийн удирдлагын газар зээлийн шалгуур, нөхцөлийг тодорхойлоход чухал үүрэгтэй оролцоно. Хүснэгт 3-аас харахад судалгаанд хамрагдсан ажилтнууд зээлийн шалгуур, нөхцөлийг талаарх шийдвэр гаргалтад нөлөөтэй газруудын захирлууд байна. Хэдийгээр газрын захирлууд зээлийн төлөвийн асуудлаар шийдвэр гаргадаг боловч нөхцөл байдлыг судалж санал боловсруулах асуудлыг ихэвчлэн ахлах мэргэжилтнүүд гүйцэтгэдэг байж болзошгүй юм.

Европын Төв банкны хэлж байгаагаар БЗС-аар чанарын тоон мэдээлэл цуглуулах зорилготой тул тоон судалгаануудын адил түүврийн тоог статистик аргаар тооцох шаардлагагүй бөгөөд түүврийн хэмжээ болон хүрээг нарийн түүврийн онол дээр тулгуурлах бус прагматик ач холбогдол дээр нь тулгуурлан сонгох хэрэгтэй гэсэн байдаг. Тиймээс ч уг судалгааг банк бүрийн зээлийн ахлах мэргэжилтнүүдээс авдаг. Америк, Японд энэ судалгааг зээлийн ахлах мэргэжилтнүүдийн санал бодлын судалгаа ч гэж нэрлэсэн байдаг. Манай нөхцөлд магадгүй санал боловсруулдаг, шийдвэр гаргадаг аль аль талыг судалгаанд хамруулвал хариулт алдаа багатай, төлөөлөх чадвар сайтай болж мэдэх юм.

Судалгааны асуулга

Монголбанкнаас авч буй БЗС-ны асуулгад дараах хэдэн зүйлсийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

Банкны зээлийн судалгааны нэг гол зорилго бол зээл олголтод үзүүлж буй эрэлтийн болон нийлүүлэлтийн хүчин зүйлсийг ялган харах явдал байдаг. Тиймээс “Танай банкны зээл олголт хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэж асуухын оронд “Танай банкны зээлийн шалгуур нөхцөл хэрхэн өөрчлөгдсөн бэ?”, “Зээлийн эрэлт хэрхэн өөрчлөгдсөн гэж бодож байна вэ?” зэргээр асуух шаардлагатай.

Монголбанкны Зээлийн төлөвийн судалгааны асуулгыг Евро бүсийн БЗС-ны асуулгад үндэслэн зохиосон тул дараах хүснэгтэд Евро бүсээс авдаг БЗС-ны асуулгын бүтцийг Монголбанкнаас авдаг БЗС-ны асуулгын бүтэцтэй харьцуулан харуулав.

Хүснэгт 3. Евро бүсийн БЗС-ны асуулгын бүтцийг Монголбанкны БЗС-ны асуулгын бүтэцтэй харьцуулсан байдал

Евро бүсийн БЗС-ны асуулгын бүтэц	Монголбанкны БЗС-ны асуулгын бүтэц
БҮЛЭГ I. ААН-д олгосон зээл	БҮЛЭГ I. Зээлийн ерөнхий төлөв
Өнгөрсөн 3 сард	Өнгөрсөн 3 сар
1) Зээлийн <i>шалгуур</i> хэрхэн өөрчлөгдсөн 2) Зээлийн <i>шалгуур</i> өөрчлөгдөхөд нөлөөлсөн хүчин зүйлс 3) Зээлийн <i>нөхцөл</i> хэрхэн өөрчлөгдсөн (үнийн болон бусад нөхцөл) 4) Эрэлт хэрхэн өөрчлөгдсөн 5) Эрэлт өөрчлөгдөхөд нөлөөлсөн хүчин зүйлс	1) Зээл <i>олголт</i> хэрхэн өөрчлөгдсөн 2) Зээл олголтод нөлөөлсөн хүчин зүйлс 3) Зээлийн <i>шалгуур</i> хэрхэн өөрчлөгдсөн (1 жил, 6 сар, 3 сар, 1 сарын өмнөхтэй харьцуулахад хэр өөрчлөгдсөн, төгрөг валют тус бүрээр ялган бичнэ) 4) Зээлийн <i>шалгуур</i> өөрчлөгдөхөд нөлөөлсөн хүчин зүйлс (төгрөг валют тус бүрээр ялган бичнэ) 5) Зээлийн <i>нөхцөл</i> хэрхэн өөрчлөгдсөн (ашиг болон бусад нөхцөлүүдийн хувьд 3 сар, 6 сар, 9 сар, 12 сар, 18 сар гэх мэтчилэн зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр зээлийн нөхцөл үзүүлэлтүүд буурсан нэмэгдсэнийг бичнэ) 6) Мөнгөний бодлогын арга хэмжээ банкны зээлийн бодлогод нөлөөлөх эсэх (1 сар, 3 сар, 6 сар, 1 жил, 18 сар, 2 жилийн дотор нөлөөлөхөөс сонгоно) 7) Эрэлт хэрхэн өөрчлөгдсөн 8) Эрэлт өөрчлөгдөхөд нөлөөлсөн хүчин зүйлс
Ирэх 3 сард	Ирэх 3 сар
1) Зээлийн <i>шалгуур</i> хэрхэн өөрчлөгдөх вэ? 2) Зээлийн эрэлт хэрхэн өөрчлөгдөх вэ?	1) Зээл олголт хэрхэн өөрчлөгдөх вэ? 2) Зээлийн эрэлт хэрхэн өөрчлөгдөх вэ?
(ААН-ын зээлийн асуултууд нь ЖДҮЭ болон Том ААН, богино болон урт хугацаат зээл гэж ангилагдана)	(ААН-ийн зээлийн асуултууд нь Нийт дүн, ЖДҮЭ, Том зээлдэгч, Орон сууцны ипотекийн зээл, Уул уурхай, Барилга Худалдаа, Үл хөдлөх, Хэрэглээний, Бусад гэх мэтчилэн ангилагдана)
БҮЛЭГ II. Өрхүүдэд олгосон зээл	БҮЛЭГ II. Өрхийн зээл
(ААН-д олгосон зээлийн асуултуудтай адил асуулт асууна)	(Зээлийн ерөнхий төлөвийн асуултуудтай адил асуулт асууна)
БҮЛЭГ III. Нээлттэй асуулт	БҮЛЭГ III. Нээлттэй асуулт
(Өрхийн зээлийн асуултууд нь Ипотекийн зээл, Хэрэглээний болон бусад зээл гэж хоёр ангилагдана)	(Өрхийн зээлийн асуултууд нь Ипотекийн зээл, Хэрэглээний болон бусад зээл гэж хоёр ангилагдана)

Евро бүсийн БЗС-ны асуулга нь зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт гэсэн үндсэн гурван бүлэг асуултаас бүрдсэн байгаа бол Монголбанкны асуулга нь зээл олголт, шалгуур, нөхцөл, эрэлт гэсэн үндсэн дөрвөн асуултаас бүрдэж байна. Хэдийгээр манай судалгаа Евро бүсийн судалгааны асуулгатай адил зээлийн шалгуур, нөхцөл, эрэлтийг асууж байгаа ч боломжит хариултууд нь хавьгүй олон бүлгүүдтэй, олон янзын хугацааны өмнөх үр дүнтэй харьцуулахыг шаардсан, зээлийг хавьгүй олон бүлэгт хуваасан байна. Жишээлбэл, орон сууцны ипотекийн зээлийн шалгуурт өөрчлөлт оруулсан бол 1 жил, 6 сар, 3 сар, 1 сарын өмнөхтэй тус бүр харьцуулахад хэр өөрчлөгдсөн, мөн дээрээс нь төгрөгийн зээлийн хувьд, валютын зээлийн хувьд тус бүр хэрхэн өөрчлөгдсөнийг ялган асуусан байна. Цаашлаад орон сууцны ипотекийн зээлээс гадна уул уурхайн зээл, барилгын зээл, худалдааны зээл, үл хөдлөх хөрөнгийн зээл, хэрэглээний зээл, бусад зээл тус бүрт дээрх байдлаар хариулах шаардлагатай болж байна.

Манай БЗС-ны бүтцийг оновчтой, товч тодорхой болгож сайжруулах шаардлагатайгаас гадна нэр томъёоны тайлбарыг судалгааны асуулгын ард хавсаргаж судалгаа авч байгаа болон өгч байгаа талууд нэгдсэн нэг ойлголттой болох шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Тухайлбал, зээлийн шалгуур (credit standard), нөхцөл (credit terms and condition), зээлийн кавенант, банкны шалгуур чангарах зэрэгт юуг ойлгох вэ гэдгийг тодорхойлж судалгааны асуулгын ард хавсаргах нь зүйтэй юм.

V. БАНКНЫ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ХЭРХЭН НЭГТГЭЖ, ТАЙЛБАРЛАХ ВЭ?

Монголбанкны хувьд БЗС-ны үр дүнг дескриптив статистик хэлбэрээр тайлагнадаг. Хүснэгт 1-т бусад орны төв банкуудын БЗС-ны нэгтгэлийн аргуудыг харьцуулсан билээ. Эдгээр банкууд цэвэр хувь болон тархалтын индекс ашиглан хариултуудыг нэгтгэсэн байна. Хариултын цэвэр хувийг зээлийн шалгуурыг чангаруулсан банкуудын эзлэх хувиас сулруулсан банкуудын эзлэх хувийг хасч тооцдог. Тархалтын индекс нь нэлээд гэсэн хариултад их жин, бага зэрэг гэсэн хариултад бага жин өгч, цэвэр хувьтай адил зээлийн шалгуурыг чангаруулсан банкуудын эзлэх хувиас сулруулсан банкуудын эзлэх хувийг хасна. Монголбанкны хувьд судалгааг дескриптив байдлаар тайлагнахын оронд цэвэр хувь болон тархалтын индексийг ашиглан хариултуудыг нэгтгэн тайлбарлах боломжтой. Ингэснээр цэвэр хувиас банкуудын дийлэнх нь зээлийг

шалгуурыг чангаруулж байна уу эсвэл сулруулж байна уу гэдгийг харах боломжтой. Түүнээс тархалтын индексийг дээрх үр дүнтэй харьцуулснаар банкууд зээлийн шалгуурыг нэлээд өөрчлөх үү эсвэл бага зэрэг өөрчлөх үү гэдгийг ялган хэлэх боломжтой болно.

5.1. Цэвэр хувь тооцох аргачлал

Цэвэр хувь (ЦХ)-ийг тооцохдоо зээлийн шалгуурыг чангаруулсан банкуудын эзлэх хувиас сулруулсан банкуудын эзлэх хувийг хасна. Бусад орнуудад ихэвчлэн том банкуудыг судалгаанд хамруулдаг учраас уг хариултыг сонгосон банкуудын тоогоор энэ үзүүлэлтийг тооцдог. Монголын нөхцөлд бүх банкуудыг хамруулж, судалгааны үр дүнг гурван бүлэг үзүүлэлтээр харуулах боломжтой. Өөрөөр хэлбэл, нийт банкны хувьд, том банкуудын хувьд, мөн бусад банкуудын хувьд тус бүрд нь дээрх үзүүлэлтийг тооцох юм. Нийт банкуудын хувьд уг үзүүлэлтийг тооцохдоо тус хариултыг сонгосон банкуудын тоог авч үзэхийн оронд зээлийн хэмжээгээр нь тооцох боломжтой уг үзүүлэлтийг тооцно. Тархалтын индексийг нийт банкуудын хувьд тооцох жишээг Хүснэгт 4-т харуулж байна.

Хүснэгт 4. Цэвэр хувь тооцох жишээ

	Нэлээд суларсан	Бага зэрэг суларсан	Онцын өөрчлөлт ороогүй	Бага зэрэг чангарсан	Нэлээд чангарсан
Уг хариултыг сонгосон банкуудын зээлийн үлдэгдлийн нийлбэр дүн (тэрбум төгрөг)	900	1,500	3,000	2,000	1,000
Уг хариултыг сонгосон банкуудын зээлийн нийт банкны салбарын зээлд эзлэх хувь	900/8,400 =11%	1,500/8,400 =18%	3,000/8,400 =36%	2,000/8,400 =24%	1,000/8,400 =12%
Цэвэр хувь	ЦХ = 12% + 24% – 18% – 11% = 8%				

ЦХ эерэг гарна гэдэг нь зээлийн шалгуурыг чангаруулсан банкуудын эзлэх хувь сулруулсан банкуудын эзлэх хувиас их байгааг харуулна. Харин ЦХ 8 хувиас өсч 9 хувь болвол зээлийн шалгуурыг чангаруулж байгаа банкуудын жин ихэсч байгааг харуулахаас бус зээлийн шалгуур улам чангарч байна гэсэн үг биш юм. Мөн ЦХ 0-тэй ойролцоо гарах нь хоёр утгыг илэрхийлж болно. Үүнд, зээлийн шалгуурыг чангаруулсан банкуудын эзлэх хувь сулруулсан банкуудын эзлэх хувьтай тэнцүү байгаа эсвэл зээлийн шалгуур бараг өөрчлөгдөөгүй гэсэн хариултыг дийлэнх банкууд сонгосон байна гэсэн үг. Дээрх хоёр шалтгааны аль нь

болохыг тоон өгөгдлийг ажиглах замаар хялбархан хэлж болно.

5.2. Тархалтын индекс тооцох аргачлал

Тархалтын индекс (ТИ)-ийг тооцохдоо нэлээд гэсэн хариултад бага зэрэг гэсэн хариултаас 2 дахин илүү ач холбогдол өгч байхаар хариултаудыг жигнэж, ЦХ-тай адил зээлийн шалгуурыг чангаруулсан банкуудын эзлэх хувиас сулруулсан банкуудын эзлэх хувийг хасна. Хүснэгт 5-д тархалтын индекс тооцох жишээг харууллаа.

Хүснэгт 5. Тархалтын индекс тооцох жишээ

	Нэлээд суларсан	Бага зэрэг суларсан	Онцын өөрчлөлт ороогүй	Бага зэрэг чангарсан	Нэлээд чангарсан
Уг хариултыг сонгосон банкуудын зээлийн үлдэгдлийн нийлбэр дүн (тэрбум төгрөг)	900	1,500	3,000	2,000	1,000
Уг хариултыг сонгосон банкуудын зээлийн нийт банкны салбарын зээлд эзлэх хувь	900/8,400	1,500/8,400	3,000/8,400	2,000/8,400	1,000/8,400
	=0.11	=0.18	=0.36	=0.24	=0.12
Хариултын жин	1	0.5	0	0.5	1
Цэвэр хувь	$ТИ = 0.12 * (1) + 0.24 * (0.5) - 0.18 * (0.5) - 0.11 * (1) = 0.04$				

ТИ эерэг гарна гэдэг нь мөн адил зээлийн шалгуурыг чангаруулсан банкуудын эзлэх хувь сулруулсан банкуудын эзлэх хувиас их байгааг харуулна. Хэрэв ТИ-ийг 100-аар үржүүлэхэд үр дүн нь ЦХ-иас нэлээд ялгаатай байвал зээлийн шалгуурын өөрчлөлтөд нэмэлт дүгнэлт хийх боломжтой. Тухайлбал, дээрх үзүүлэлтүүд нь эерэг гарсан бөгөөд ТИ нь ЦХ-иас хавьгүй өндөр байвал зээлийн шалгуур нэлээд чангарч байгааг харин хавьгүй бага байвал зээлийн шалгуур бага зэрэг чангарч байгааг харуулна.

IV. ДҮГНЭЛТ

Банкны зээлийн судалгаа бол зээлийн төлөв, хандлага цаашлаад мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад шаардлагатай зээлийн сувгийн талаарх мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой чанарын судалгаа юм. Уг судалгаа нь банкуудын зээл, хүүгийн статистик мэдээлэлтэй хослон ашиглагдах бөгөөд зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв, банкуудын баримталж буй бодлогын талаарх мэдээллийг нэмэгдүүлэх давуу талтай.

Монголбанкнаас энэ төрлийн судалгааг 3 удаа авсан боловч бүтэц, агуулга, давтамжийн хувьд бусад орнуудын судалгаанаас эрс ялгаатай байсан байна. Уг судалгааны асуулгыг харвал БЗС-ны гол зорилго, ач холбогдлыг илэрхийлэхүйц асуулгатай гэж дүгнэхэд хүндрэлтэй юм. Иймд БЗС-г олон улсад жишиг болсон Европ, Америк, Японы төв банкуудын туршлагаар шинэчлэн явуулах нь зүйтэй. Түүнчлэн, судалгааг явуулахын тулд бэлтгэл болгон банк бүрээс судалгаанд хамруулвал зохих ажилтныг судлах, банкуудад БЗС-ны зорилго ач холбогдлыг тайлбарлаж, судалгааны асуулгыг ойлгомжтой болгох үүднээс сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэх хэрэгтэй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Berg, J., Van Rixtel, A., Ferrando, A., De Bondt, G. and Scopel, S. (2005) ‘*The Bank Lending Survey for the Euro Area*’, Available at: <https://www.ecb.europa.eu/pub/pdf/scops/ecbocp23.pdf?1751a88141a8b8beba2bc01a96085f30>
- De Bondt, G., Peydró, J.-L., Scopel, S. and Maddaloni, A. (2010) ‘The Euro Area Bank Lending Survey Matters: Empirical Evidence for Credit and Output Growth’, *Working Paper Series*, No 1160, February 2010. Available at: <http://edz.bib.uni-mannheim.de/daten/edz-ki/ezb/10/w-paper/ecbwp1160.pdf>
- Emerging Markets Bank Lending Conditions Survey* (2015) Institute of International Finance.
- Euro Area Bank Lending Survey* (2015) Available at: https://www.ecb.europa.eu/stats/pdf/blssurvey_201601.pdf?4bd32f9c94e348f242a3d86d5dbd029a.
- Lown, C.S. and Morgan, D.P. (2006) ‘The credit cycle and the business cycle: New findings using the Loan Officer opinion survey’, *Journal of Money, Credit, and Banking*, 38(6), pp. 1575–1597.
- Senior Loan Officer Opinion Survey on Bank Lending Practices* (2016) Available at: <https://www.federalreserve.gov/boarddocs/sloansurvey/201602/fullreport.pdf>
- Senior Loan Officer Opinion Survey on Bank Lending Practices at Large Japanese Banks* (2016) Available at: <http://www.boj.or.jp/en/statistics/dl/loan/loos/release/loos1601.pdf>.

ХАВСРАЛТ А. БЗС-НЫ ТАЙЛАГНАЛЫН ЖИШЭЭ

Тайлагналын жишиг



БАНКНЫ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

/2016 оны 1 дүгээр улирал/

Зээлийн шалгуур, нөхцөл: Банкууд 2016 оны 1 дүгээр улиралд бүх төрлийн зээлийн шалгуур, нөхцлөө чангаруулсан байна. Түүнчлэн банкууд 2016 оны 2 дугаар улиралд зээлийн шалгуур, нөхцлөө чангална гэсэн хүлээлттэй байна.


Зээлийн эрэлт: ААН-ийн болон өрхийн зээлийн эрэлт 2016 оны 1 дүгээр улиралд буурсан гэж банкууд мэдээлсэн. Түүнчлэн ирэх улиралд зээлийн эрэлт нэмж буурна гэсэн хүлээлттэй байна.

I. ЗЭЭЛИЙН ШАЛГУУР, НӨХЦӨЛ, ЭРЭЛТ


1.1 АЖ АХУЙ НЭГЖ

Зураг 1. ААН-ийн зээлийн шалгуур

(зээлийн шалгуурыг чангаруулж буй банкуудын хариултын цэвэр хувь)




Зураг 2. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлсөн хүчин зүйлс (Нийт зээл)
(зээлийн шалгуур чангаруулж буй банкуудын хариултын цэвэр хувь)



ААН-ийн зээлийн шалгуур чангарахад эх үүсвэрийн зардал ба балансын хязгаарлалт болон банкуудын эрсдэлийн үнэлэмж хамгийн их нөлөөлсөн байна.


Зураг 3. ААН-ийн зээлийн нөхцөл (Нийт зээл)
(зээлийн нөхцөлийг чангаруулж буй банкуудын хариултын цэвэр хувь)




ААН-ийн зээлийн нөхцөл гэдэгт зээлдүүлэгч болон зээлдэгчийн харилцан тохиролцсон зээлийн дүн, хугацаа, хүү болон бусад нөхцөлийг ойлгоно. ХЦХ 0 гэсэн угтатай ойролцоо гарсан бөгөөд үүнийг хоёр байдлаар тайлбарлаж болно. Зээлийг нөхцөлийг чангаруулсан банкуудын эзлэх хувь сулруулсан банкуудын эзлэх хувьтай бараг тэнцүү байгаа эсвэл дийлэнх банкууд зээлийн нөхцөлийг бараг өөрчлөөгүй гэж хариулсан байж болох талтай.

Дээрх хоёр шалтгааны аль нь болохыг тоон өгөгдлөөс харж дүгнэх боломжтой бөгөөд дийлэнх банкууд зээлийн нөхцөл бараг өөрчлөгдөөгүй гэсэн хариултыг сонгосон байна.

Зураг 4. ААН-ийн зээлийн нөхцөлд нөлөөлсөн хүчин зүйлс (Нийт зээл) (зээлийн нөхцөлийг чангаруулж буй банкуудын хариултын цэвэр хувь)



Зураг 5. ААН-ийн зээлийн эрэлт (зээлийн эрэлт өссөн гэсэн банкуудын хариултын цэвэр хувь)



ААН-ийн зээлийн эрэлт өссөн гэж мэдээлсэн банкуудын эзлэх хувь өсөх хандлагатай байна. *Бусад тайлбарыг хийнэ.*

1.2 ӨРХ

Энэ хэсэг бүтцийн хувьд өмнөх бүлэгтэй адил байна.

II. НЭМЭЛТ АСУУЛТ

Энэ хэсэг бүтцийн хувьд асуултаас хамааран өөрчлөгдөж болно.

III. ДҮГНЭЛТ

БЗС-ны 2016 оны 1 дүгээр улирлын үр дүнгээс харахад банкуудын зээлийн шалгуур чангарсан, зээлийн нөхцөл хэвэндээ байгаа, зээлийн эрэлт нэмэгдсэн дүр зураг ажиглагдаж байна.

Зээлийн шалгуурыг чангаруулахад эх үүсвэрийн зардал болон эрсдэлийн үзүүлэлтүүд голчлон нөлөөлсөн байна. Зээлийн эрэлт өсч байгаа үед зээлийн шалгуур чангарч байгаа нь зээл тасалдал үүсэх эрсдэл байж болзошгүйг харуулж байна. *Бусад тайлбарыг хийнэ.*

ХАВСРАЛТ В. БЗС-НЫ АСУУЛГЫН ЖИШЭЭ (ЕВРО БҮСИЙН БЗС-НЫ АСУУЛГА)

Монголбанкны Банкны зээлийн судалгаа

Маягт БЗС-1

БАНКНЫ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ АСУУЛГА ... ОНЫ ... ДУГААР УЛИРАЛ

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Санал асуулгад оролцогчын товч мэдээлэл

Банкны нэр:	<input type="text"/>
Албан тушаал:	<input type="text"/>
Санал асуулгад оролцсон огноо:	<input type="text"/> он <input type="text"/> сар <input type="text"/> өдөр

АЖ АХУЙ НЭГЖИЙН ЗЭЭЛ

1. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны ААН-ийн зээлийн шалгуур хэрхэн өөрчлөгдсөн бэ?

	Нийт	Жижиг, дунд ААН-д олгосон зээл*	Том ААН-д олгосон зээл	Богино хугацаатай зээл	Урт хугацаатай зээл
Нэлээд чангарсан					
Бага зэрэг чангарсан					
Онцын өөрчлөлт ороогүй					
Бага зэрэг суларсан					
Нэлээд суларсан					

*Зээлийг богино болон урт хугацаатай, жижиг дунд болон том ААН-үүдийн хэмээн хувааж байгаа нь харилцан хамааралгүй хоёр ангилал гэдгийг анхаарна уу.

2. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны ААН-ийн зээлийн шалгуур (Асуулт 1-т тодорхойлсны дагуу)-т дараах хүчин зүйлс хэрхэн нөлөөлсөн бэ?

Зээлийн шалгуурыг чангаруулахад эсвэл сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг дор өгөгдсөн шаталбараар үнэлнэ үү.

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
- = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
- 0 = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
- ++ = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
- NA = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
= нөлөө үзүүлээгүй

	Нийт						Жижиг, дунд ААН-үүдэд олгосон зээл						Том ААН-үүдэд олгосон зээл					
	--	-	0	+	++	NA	--	-	0	+	++	NA	--	-	0	+	++	NA
А. Эх үүсвэрийн зардал болон балансын хязгаарлалт																		
1																		
2																		
3																		
В. Өрсөлдөөний дарамт																		
1																		
2																		
3																		
С. Эрсдэлийн үнэлэмж																		
1																		

2	Зээл олгож буй салбар эсвэл компанийн төлөв байдал																			
3	Барьцаа хөрөнгийн эрсдэл																			
D. Бусад хүчин зүйлс (тодорхойлно уу)																				

3. Өнгөрсөн 3 сарын хугацаанд ААН-ийн зээлийн нөхцөл хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Зээлийн нөхцөлийг чангаруулахад эсвэл сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг дор өгөгдсөн шаталбараар үнэлнэ үү.

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
- = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
- O** = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
- + = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
- ++ = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
- NA** = нөлөө үзүүлээгүй

		Нийт						Жижиг, дунд ААН-үүдэд олгосон зээл						Том ААН-үүдэд олгосон зээл						
		--	-	O	+	++	NA	--	-	O	+	++	NA	--	-	O	+	++	NA	
A. Үнэ																				
1	Танай банкны зээлийн дундаж маржа (маржа нэмэгдвэл = чангаруулалт, маржа буурвал = сулруулалт)																			
2	Танай банкны эрсдэл өндөртэй зээлийн маржа																			
B. Бусад нөхцөл																				
1	Хүүний бус шимтгэл, хураамж																			
2	Зээл (зээлийн шугам)-ийн хэмжээ																			
3	Барьцаа хөрөнгийн шаардлага																			
4	Зээлдэгчид гэрээгээр хүлээлгэх үүрэг																			
5	Хугацаа (maturity)																			
C. Бусад хүчин зүйлс (тодорхойлно уу)																				

4. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны **ААН-ийн зээлийн эрэлт** хэрхэн өөрчлөгдсөн бэ? (хэвийн үед үүсдэг улирлын шинжтэй өөрчлөлтөөс бусад өөрчлөлтийг авч үзнэ үү).

	Нийт	Жижиг, дунд ААН-д олгосон зээл*	Том ААН-д олгосон зээл	Богино хугацаатай зээл	Урт хугацаатай зээл
Нэлээд чангарсан					
Бага зэрэг чангарсан					
Онцын өөрчлөлт ороогүй					
Бага зэрэг суларсан					
Нэлээд суларсан					

* Зээлийг богино болон урт хугацаатай, жижиг дунд болон том ААН-үүдийн хэмээн хувааж байгаа нь харилцан хамааралгүй хоёр ангилал гэдгийг анхаарна уу.

5. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны **ААН-ийн зээлийн эрэлт** (Асуулт 4-н “Нийт” гэсэн баганад тодорхойлсны дагуу)-т дараах хүчин зүйлс хэрхэн нөлөөлсөн бэ?

Хүчин зүйлсийн нөлөөллийг дор өгөгдсөн шаталбараар үнэлнэ үү.

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
- = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
- О = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
- + = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
- ++ = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
- NA = нөлөө үзүүлээгүй

	--	-	О	+	++	NA
A. Санхүүжилтийн хэрэгцээ						
1 Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт						
2 Эргэлтийн хөрөнгө болон ажлын капитал						
3 Өөр бизнес худалдаж авах, нэгдэж нийлэх болон компанийн бүтцийн өөрчлөлт						
4 Өрийн бүтцийг өөрчлөх (debt restructuring)						
B. Альтернатив санхүүжилтийн ашиглалт						
1 Дотоод санхүүжилт						

2	Бусад банкны зээл						
3	Банк бус санхүүгийн байгууллагын зээл						
4	Өрийн үнэт цаас гаргах						
5	Хувьцаа гаргах						
С. Бусад хүчин зүйлс /тодорхойлно уу/							

6. Ирэх 3 сард танай банкны **ААН-ийн зээлийн шалгуур** хэрхэн өөрчлөгдөхөөр хүлээгдэж байна вэ?

	Нийт	Жижиг, дунд ААН-д олгосон зээл*	Том ААН-д олгосон зээл	Богино хугацаатай зээл	Урт хугацаатай зээл
Нэлээд чангарна					
Бага зэрэг чангарна					
Онцын өөрчлөлт орохгүй					
Бага зэрэг суларна					
Нэлээд суларна					

*Зээлийг богино болон урт хугацаатай, жижиг дунд болон том ААН-үүдийн хэмээн хувааж байгаа нь харилцан хамааралгүй хоёр ангилал гэдгийг анхаарна уу.

7. Ирэх 3 сард танай банкны **ААН-ийн зээлийн эрэлт** хэрхэн өөрчлөгдөхөөр хүлээгдэж байгаа вэ?

	Нийт	Жижиг, дунд ААН-д олгосон зээл*	Том ААН-д олгосон зээл	Богино хугацаатай зээл	Урт хугацаатай зээл
Нэлээд буурна					
Бага зэрэг буурна					
Онцын өөрчлөлт гарахгүй					
Бага зэрэг нэмэгдэнэ					
Мэдэгдэхүйц нэмэгдэнэ					

*Зээлийг богино болон урт хугацаатай, жижиг дунд болон том ААН-үүдийн хэмээн хувааж байгаа нь харилцан хамааралгүй хоёр ангилал гэдгийг анхаарна уу.

ӨРХИЙН ЗЭЭЛ

1. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны өрхийн зээлийн шалгуур хэрхэн өөрчлөгдсөн бэ?

	Орон сууцны ипотекийн зээл	Хэрэглээний болон бусад зээл
Нэлээд буурсан		
Бага зэрэг буурсан		
Онцын өөрчлөлт гараагүй		
Бага зэрэг нэмэгдсэн		
Мэдэгдэхүйц нэмэгдсэн		

2. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны орон сууцны ипотекийн зээлийн шалгуур (Асуулт 1-д тодорхойлсны дагуу)-г дараах хүчин зүйлс хэрхэн нөлөөлсөн бэ?

Зээлийн шалгуурыг чангаруулахад эсвэл сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг дор өгөгдсөн шаталбараар үнэлнэ үү.

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
- = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
- О = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
- + = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
- ++ = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
- NA = нөлөө үзүүлээгүй

	--	-	О	+	++	NA
A. Эх үүсвэрийн зардал болон балансын хязгаарлалтууд						
B. Өрсөлдөөний дарамт						
1 Бусад банктай өрсөлдөх дарамт						
2 Банк бустай өрсөлдөх дарамт						
C. Эрсдэлийн үнэлэмж						
1 Дотоод санхүүжилт						
2 Бусад банкны зээл						
3 Банк бус санхүүгийн байгууллагын зээл						
4 Өрийн үнэт цаас гаргах						
5 Хувьцаа гаргах						
C. Бусад хүчин зүйлс (тодорхойлно уу)						

3. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны орон сууцны ипотекийн зээлийн нөхцөл өөрчлөгдсөн үү?

Зээлийн нөхцөлийг чангаруулахад эсвэл сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг дор өгөгдсөн шаталбараар үнэлнэ үү.

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
 - = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
 O = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
 + = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
 ++ = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
 NA = нөлөө үзүүлээгүй

		--	-	O	+	++	NA
A. Үнэ							
1	Танай банкны зээлийн дундаж маржа (маржа нэмэгдвэл=чангаруулалт, маржа буурвал=сулруулалт)						
2	Танай банкны эрсдэл өндөртэй зээлийн маржа						
B. Бусад нөхцөл							
1	Барьцаа хөрөнгийн шаардлага						
2	Зээл-үнэлгээний харьцаа						
3	Хугацаа /maturity/						
4	Хүүний бус шимтгэл, хураамж						
C. Бусад хүчин зүйлс /тодорхойлно уу/							

4. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны өрхийн хэрэглээний болон бусад зээлийн шалгуур (Асуулт 1-д тодорхойлсны дагуу)-т дараах хүчин зүйлс хэрхэн нөлөөлсөн бэ?

Зээлийн шалгуурыг чангаруулахад эсвэл сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг дор өгөгдсөн шаталбараар үнэлнэ үү.

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
 - = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
 O = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
 + = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
 ++ = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
 NA = нөлөө үзүүлээгүй

	--	-	0	+	++	NA
A. Эх үүсвэрийн зардал болон балансын хязгаарлалт						
B. Өрсөлдөөний дарамт						
1 Бусад банктай өрсөлдөх дарамт						
2 Банк бустай өрсөлдөх дарамт						
C. Эрсдэлийн үнэлэмж						
1 Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдлын хүлээлт						
2 Харилцагчдын төлбөрийн чадвар						
3 Барьцаа хөрөнгийн эрсдэл						
D. Бусад хүчин зүйлс /тодорхойлно уу/						

5. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны өрхийн хэрэглээний болон бусад зээлийн нөхцөл хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Зээлийн нөхцөлийг чангаруулахад эсвэл сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг дор өгөгдсөн шаталбараар үнэлнэ үү.

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
 - = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
 0 = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
 + = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
 ++ = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
 NA = нөлөө үзүүлээгүй

	--	-	0	+	++	NA
A. Үнэ						
1 Танай банкны зээлийн дундаж маржа (маржа нэмэгдвэл=чангаруулалт, маржа буурвал=сулруулалт)						
2 Танай банкны эрсдэл өндөртэй зээлийн маржа						
B. Бусад нөхцөл						
1 Барьцаа хөрөнгийн шаардлага						
3 Хугацаа /maturity/						
4 Хүүний бус шимтгэл, хураамж						
C. Бусад хүчин зүйлс /тодорхойлно уу/						

6. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны **өрхийн зээлийн эрэлт** хэрхэн өөрчлөгдсөн бэ (улирлын нөлөөллөөс бусад өөрчлөлтийг авч үзнэ үү)?

	Орон сууцны ипотекийн зээл	Хэрэглээний болон бусад зээл
Нэлээд буурсан		
Бага зэрэг буурсан		
Онцын өөрчлөлт гараагүй		
Бага зэрэг нэмэгдсэн		
Мэдэгдэхүйц нэмэгдсэн		

7. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны **өрхийн орон сууцны ипотекийн зээлийн эрэлтэд** (Асуулт 6-т тодорхойлсны дагуу) дараах хүчин зүйлс хэрхэн нөлөөлсөн бэ? Хүчин зүйлсийн нөлөөг үнэлэхдээ дор өгөгдсөн шаталбарыг ашиглана уу:

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
- = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
- О = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
- + = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
- ++ = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
- NA = нөлөө үзүүлээгүй

		--	-	О	+	++	NA
А. Санхүүжилтийн хэрэгцээ							
1	Орон сууцны зах зээлийн ирээдүйн төлөв байдал						
2	Хэрэглэгчийн итгэл						
3	Орон сууцны бус хэрэглээний зардал						
В. Альтернатив санхүүжилтийн ашиглалт							
1	Өрхийн хуримтлал						
2	Бусад банкны зээл						
3	Санхүүгийн бусад эх үүсвэр						
С. Бусад хүчин зүйлс /тодорхойлно уу/							

8. Өнгөрсөн 3 сарын хугацаанд танай банкны **өрхийн хэрэглээний болон бусад зээлийн эрэлтэд** (Асуулт 6-т тодорхойлсны дагуу) дараах хүчин зүйлс хэрхэн нөлөөлсөн бэ? Хүчин зүйлсийн нөлөөг үнэлэхдээ дор өгөгдсөн шаталбарыг ашиглана уу

- = зээлийн шалгуурыг чангаруулахад нэлээд нөлөөлсөн
 - = зээлээ шалгуурыг чангаруулахад бага зэрэг нөлөөлсөн
 O = зээлийн шалгуурт онцын нөлөө үзүүлээгүй
 + = зээлийн шалгуурыг сулруулахад бага зэрэг нөлөөлсөн
 ++ = зээлийн шалгуурыг сулруулахад нэлээд нөлөөлсөн
 NA = нөлөө үзүүлээгүй

		--	-	O	+	++	NA
A. Санхүүжилтийн хэрэгцээ							
1	Удаан эдэлгээтэй бараа (автомашин, мебель г.м.)-ны худалдан авалтын зарцуулалт						
2	Хэрэглэгчийн итгэл						
3	Үнэт цаасны худалдан авалт						
B. Альтернатив санхүүжилтийн ашиглалт							
1	Өрхийн хуримтлал						
2	Бусад банкны зээл						
3	Санхүүгийн бусад эх үүсвэр						
C. Бусад хүчин зүйлс /тодорхойлно уу/							

9. Ирэх 3 сарын хугацаанд танай банкны **өрхийн зээлийн шалгуур** хэрхэн өөрчлөгдөхөөр хүлээгдэж байгаа вэ?

	Орон сууцны ипотекийн зээл	Хэрэглээний болон бусад зээл
Нэлээд чангарна		
Бага зэрэг чангарна		
Онцын өөрчлөлт орохгүй		
Бага зэрэг суларна		
Нэлээд суларна		

10. Ирэх 3 сарын хугацаанд танай банкны **өрхийн зээлийн эрэлт** хэрхэн өөрчлөгдөхөөр хүлээгдэж байгаа вэ? (улирлын нөлөөллөөс бусад өөрчлөлтийг авч үзнэ үү).

	Орон сууцны ипотекийн зээл	Хэрэглээний болон бусад зээл
Нэлээд буурна		
Бага зэрэг буурна		
Онцын өөрчлөлт гарахгүй		
Бага зэрэг нэмэгдэнэ		
Мэдэгдэхүйц нэмэгдэнэ		

НЭМЭЛТ АСУУЛТ

Энэ судалгаагаар авч үзээгүй боловч танай банкы зээлийн орчинд нөлөөлсөн ямар үйл явдал/хүчин зүйл өнгөрсөн 3 сарын хугацаанд үүссэн бэ?

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Банк бус байгууллагууд (Non-banks) Даатгалын компаниуд, тэтгэврийн сангууд, хадгаламж зээлийн хоршоо болон бусад банк бус санхүүгийн зуучлагчид.

Барьцаа (Collateral) Зээлдэгчийн өр төлбөрийг төлөх үүрэг хүлээж барьцаа болгосон, өр төлбөрөө төлөөгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг хангах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх. Барьцаа хөрөнгийн үүргийг санхүүгийн актив (тухайлбал, бонд, хувьцаа), үл хөдлөх хөрөнгө, заавал байлгах үлдэгдэл (Compensating Balances) зэргээр гүйцэтгүүлж болно. Заавал байлгах үлдэгдэл гэдэг нь зээлийн тодорхой хувийг дансандаа байлгах шаардлага юм.

Богино хугацаатай зээл (Short-term loans) Нэг жил хүртэлх хугацаатай зээл.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч (Small and medium-sized enterprises) 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нэгж, иргэнийг хэлнэ (Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 2.5 дугаар заалт).

Зээл үнэлгээний харьцаа (LTV ratio) Зээл үнэлгээний харьцаа гэж зээлийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд харьцуулсан хувь хэмжээг хэлнэ.

Зээлдэгчид гэрээгээр хүлээлгэсэн үүрэг (Loan covenants) Зээлдэгчийг зээлийн хугацаанд тодорхой үйлдэл хийхийг шаардсан эсвэл хязгаарласан зээлийн гэрээний нөхцөл. Тухайлбал, зээлийн хугацаанд зээлдэгчийг өөрийн үйл ажиллагааны талаарх тодорхой мэдээллийг зээл олгогчид тогтмол ирүүлж байхыг шаардах. Энэ нь зээлийн нөхцөлий нэг хэсэг юм.

Зээлийн нөхцөл (Credit terms and conditions) Зээлдүүлэгч болон

зээлдэгчийн харилцан тохиролцсон зээлийн дүн, хугацаа, хүү болон бусад нөхцөлийг ойлгоно. Энэхүү судалгаанд зээлийн нөхцөл нь үнийн болон үнийн бус гэж хоёр ангилагдана. Үнийн зээлийн нөхцөл гэдэгт хүү болон зээл олгохтой холбоотой бусад хураамжийг ойлгох бол үнийн бус зээлийн нөхцөлд зээлийн дээд хэмжээ, хугацаа, зээлдэгчид гэрээгээр хүлээлгэсэн үүрэг, барьцаа хөрөнгийн шаардлага зэргийг авч үзнэ.

Зээлийн шалгуур (*Credit standards*) Зээлдэгчийг зээлийн шаардлага хангах эсэхийг тодорхойлдог банкны дотоод журам, аргачлал, процедур. Тухайлбал, зээлдэгчийн өр-орлогын харьцааг тооцож, тодорхой хязгаар заах.

Зээлийн шугам (*Credit line*) Зээлдэгчид тодорхой хугацааны турш зөвшилцсөн хязгаарын хүрээнд зээл олгож байхаар банк үүрэг хүлээхийг зээлийн шугамын зээл гэнэ.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний асуудал (*Capital requirement*) Санхүүгийн болон үйл ажиллагааны зарим нэг эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй байхыг шаардсан хуулийн зохицуулалтууд. Энэхүү судалгаанд банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа алдагдах эрсдэл үүсч, зээлийн стандартыг өөрчлөх шаардлага тулгарсан асуудлыг авч үзнэ.

Урт хугацаатай зээл (*Long-term loans*) Нэг жилээс дээш хугацаатай зээл.

Хугацаа (*Maturity*) Зээлийн хугацаа. Энэ судалгаанд богино болон урт хугацаат зээлийн аль алины хугацааг авч үзнэ.

Хүүний бус шимтгэл, хураамж (*Non-interest rate charges*) Зээлтэй холбоотой төрөл бүрийн шимтгэл хураамж (тухайлбал, өргөдлийн хураамж, баталгаа эсвэл зээлийн даатгал зэрэгт шаардагдах хураамж).

Хэрэглэгчийн итгэл (*Consumer confidence*) Монгол улсын санхүү, эдийн засгийн нөхцөл байдалд өгч буй хэрэглэгчийн үнэлгээ. Хэрэглэгчийн итгэл өөрчлөгдөх нь түүний худалдан авалтын болоод зээлийн шийдвэр гаргалтад нөлөөлнө. Тухайлбал, хэрэглэгчийн итгэл муудахад удаан эдэлгээнтэй барааны худалдан авалт муудаж, энэ төрлийн хэрэглээний зээлийн эрэлт буурна.

Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдлын хүлээлт (*Expectations regarding general economic situation*) Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдлыг банк хэрхэн таамаглаж, ямар хариу үйлдэл үзүүлж байгааг авч үзнэ. Энэ төрлийн хүлээлтэд эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалт, экспорт, импорт, ажилгүйдлийн талаарх хүлээлт зэрэг орно.

**ХАВСРАЛТ С. МОНГОЛБАНКНААС ЯВУУЛСАН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВИЙН СУДАЛГААНЫ
НИЙЦЭЙ БАЙДЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

БЗС-аар гарсан үр дүн (2012 оны 11 дүгээр сар)		Банкны бэлэн дээрх үр дүн					
Нийт зээл олголт		Валютын зээл		Нийт зээл олголт		Валютын зээл	
Өнгөрсөн	Ирэх	Өнгөрсөн	Ирэх	Дундаж өсөлт (2010-2015)	Өнгөрсөн 3 сарын дундаж өсөлт	Дундаж (2010-2015)	Өнгөрсөн 3 сарын дундаж өсөлт
Банк 1	Бага зэрэг нэмэгдэнэ	Бага зэрэг буурсан	Бага зэрэг нэмэгдэнэ	1.0094	1.0378	1.0180	1.0067
Банк 2	Бага зэрэг нэмэгдэнэ	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдэнэ	1.0136	1.0184	1.0038	1.0115
Банк 3	Нэлээд нэмэгдсэн	Өөрчлөгдөөгүй	Өөрчлөгдөөгүй	1.0060	1.0172	1.0088	0.9957
Банк 4	Нэлээд нэмэгдсэн	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдэнэ	1.0464	1.0570	0.9791	1.0029
Банк 5	Бага зэрэг багассан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдэнэ	1.0126	1.0145	1.0077	1.0022
Банк 6	Нэлээд нэмэгдсэн	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг буурна	1.0356	1.0501	0.9962	1.0508
Банк 7	Бага зэрэг багассан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг буурна	1.0110	1.0056	1.0168	1.0120
Банк 8	Бага зэрэг нэмэгдсэн	Нэлээд их нэмэгдсэн	Нэлээд их нэмэгдэнэ	1.0155	1.0190	0.9186	1.0270
Банк 9	Бага зэрэг багассан	Бага зэрэг нэмэгдэнэ	Өөрчлөгдөөгүй	0.9912	0.9867	1.0056	0.9801
Банк 10	Бага зэрэг нэмэгдсэн	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг буурна	0.9961	0.9796	0.9760	0.9859
Банк 11	Нэлээд нэмэгдсэн	Нэлээд их нэмэгдэнэ	Нэлээд их нэмэгдэнэ	0.9928	1.0593	1.0882	0.9944
Банк 12	Бага зэрэг багассан	Бага зэрэг буурсан	Бага зэрэг буурна	1.0046	1.0210	1.0932	1.0057
БЗС-аар гарсан үр дүн (2014 оны 8 дугаар сар)		Банкны бэлэн дээрх үр дүн					
Нийт зээл олголт		Валютын зээл		Нийт зээл олголт		Валютын зээл	
Өнгөрсөн	Ирэх	Өнгөрсөн	Ирэх	Дундаж өсөлт (2010-2015)	Өнгөрсөн 3 сарын дундаж өсөлт	Дундаж (2010-2015)	Өнгөрсөн 3 сарын дундаж өсөлт
Банк 1	Бага зэрэг нэмэгдэнэ	Нэлээд багассан	Бага зэрэг багасна	1.0094	1.0182	1.0121	1.0067
Банк 2	Бага зэрэг багассан	Нэлээд багассан	Бага зэрэг багасна	1.0136	1.0173	1.0048	1.0115
Банк 3	Нэлээд багассан	Нэлээд багассан	Нэлээд багасна	1.0060	0.9973	0.9957	1.0223
Банк 4	Бага зэрэг нэмэгдэнэ	Өөрчлөгдөөгүй	Өөрчлөгдөөгүй	1.0464	1.0144	0.9969	1.0029
Банк 5	Бага зэрэг нэмэгдэнэ	Нэлээд багассан	Нэлээд багасна	1.0126	1.0193	1.0307	1.0022
Банк 6	Бага зэрэг нэмэгдэнэ	Бага зэрэг багассан	Бага зэрэг багасна	1.0356	1.0395	1.0212	1.0508
Банк 7	Өөрчлөгдөөгүй	Нэлээд багассан	Бага зэрэг багасна	1.0110	1.0324	1.0095	1.0120
Банк 8	Нэлээд нэмэгдсэн	Бага зэрэг багассан	Нэлээд багасна	1.0155	1.0354	1.0433	1.0270
Банк 9	Бага зэрэг багассан	Нэлээд багассан	Нэлээд багасна	0.9912	0.9968	0.9850	0.9801
Банк 10	Өөрчлөгдөөгүй	Нэлээд багассан	Нэлээд багасна	0.9961	1.0122	1.0337	0.9859

Нийт зээл олголт		Валютын зээл		Банкны баланс дээрх үр дүн					
БЗС-аар гарсан үр дүн (2015 оны 2 дугаар сар)		Валютын зээл		Нийт зээл олголт		Валютын зээл			
Өнгөрсөн	Ирэх	Өнгөрсөн	Ирэх	Дундаж өсөлт (2010-2015)	Өнгөрсөн 3 сарын дундаж өсөлт	Ирэх 3 сарын дундаж өсөлт	Дундаж (2010-2015)	Өнгөрсөн 3 сарын дундаж өсөлт	Ирэх 3 сарын дундаж өсөлт
Банк 1	Бага зэрэг нэмэгдсэн	Нэлээд буурсан	Барал өөрчлөгдөхгүй	1.0094	0.9907	1.0061	1.0067	1.0160	0.9954
Банк 2	Бага зэрэг буурсан	Барат өөрчлөгдөхгүй	Бага зэрэг буурсан	1.0136	0.9637	0.9945	1.0115	0.9820	0.9813
Банк 3	Нэлээд буурсан	Барат өөрчлөгдөхгүй	Барат өөрчлөгдөхгүй	1.0060	0.9604	0.9982	0.9957	0.9793	1.0337
Банк 4	Бага зэрэг нэмэгдсэн	Барат өөрчлөгдөхгүй	Нэлээд буурсан	1.0464	0.9823	0.9972	1.0029	0.8901	0.9536
Банк 5	Бага зэрэг буурсан	Барал өөрчлөгдөхгүй	Нэлээд буурсан	1.0126	1.0091	1.0037	1.0022	0.9434	0.9658
Банк 6	Бага зэрэг нэмэгдсэн	Бага зэрэг нэмэгдсэн	Барат өөрчлөгдөхгүй	1.0356	1.0117	1.0149	1.0508	1.0226	0.9404
Банк 7	Бага зэрэг буурсан	Барат өөрчлөгдөхгүй	Бага зэрэг буурсан	1.0110	0.9709	0.9957	1.0120	0.9579	0.9853
Банк 8	Бага зэрэг буурсан	Бага зэрэг нэмэгдсэн	Бага зэрэг нэмэгдсэн	1.0155	1.0274	1.0154	1.0270	1.0579	0.9545
Банк 9	Бага зэрэг буурсан	Нэлээд буурсан	Нэлээд буурсан	0.9912	0.9883	1.0125	0.9801	1.1177	0.9995
Банк 10	0	0	0	0.9961	1.0145	0.9983	0.9859	1.0149	0.9886

Банкны харуулт болит байдалтай бүрэн нийцсэн
Банкны харуултын чиглэл (өссөн, буурсан) болит байдалтай нийцсэн боловч хэмжээ нь нийцээгүй
Банкны харуулт болит байдалтай огт нийцээгүй

Шалгуур үзүүлэлт
Нэлээд буурсан
Бага зэрэг буурсан
Барат өөрчлөгдөхгүй
Бага зэрэг нэмэгдсэн
Нэлээд нэмэгдсэн